



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/29

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтууд, Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 3/97 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр санхүүжих 9,900,000 (Есөн сая есөн зуун мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороог нэгдүгээр хавсралтаар, тус Засаг даргын Тамгын газарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар 30,000,000 (Гучин сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий техник, тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17 -ны өдрийн А/29 дүгээр
захирамжийн 01 дүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ "АЙМГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ" ЗӨВЛӨХИЙН БУС
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-9,900,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Х.Цэнд-Аюуш-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга


Гишүүд: Б.Гантулга-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн мэргэжилтэн

Ц.Ганболд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Б.Цэцгээ-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

Нарийн бичгийн дарга: З.Батбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн А/29 дүгээр
захирамжийн 02 дугаар хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ТЕХНИК,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-30,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Х.Цэнд-Аюуш-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Гантулга-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн мэргэжилтэн

Ц.Ганболд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Б.Цэцгээ-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

Нарийн бичгийн дарга: З.Батбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн